

# НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ТОХИЖИЛТ, ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС


## ТАЙЛАН

Зөвшөөрлийн тухай хуулийн дагуу  
зохион байгуулсан ажлын тухай

2023 Оны 05 дугаар сарын 15-ны өдөр

Архи согтууруулах ундаа худалддаг, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй цэгийн тоо хороо тус бүрээр гарган УБЗАА-нд судалгааг хүргэв.



Мөн шинэчлэгдсэн судалгааг [bagakhangai.ub.gov.mn](http://bagakhangai.ub.gov.mn) цахим хуудас, нүүр хуудаст ил тод байдал цонх, төрийн үйлчилгээний цонхонд тусгай зөвшөөрөл авахад шаардагдах бүрдүүлэх материалын жагсаалтыг байрлуулан, иргэн, худалдаа үйлчилгээний газар, олон нийтэд түгээн ажиллав.





| ТАХАГ ХАГААДА НЭЭ АНГАМГАА АН БУСГАА ТӨРӨЛӨНДӨР<br>ОЛГОХ ХУДАЛДАА ТУХАЙНХАА БАЙГУУЛЛАХ, НЭГЭЭ |               |             |           |           |
|-----------------------------------------------------------------------------------------------|---------------|-------------|-----------|-----------|
| Д/д                                                                                           | Хүний нэр     | Хүний нэр   | Хүний нэр | Хүний нэр |
| 1                                                                                             | Алтантөгс ХЭН | С.Монгол    | Хүний нэр | Хүний нэр |
| 2                                                                                             | Халгал БУЛА   | Д.Алтантөгс | Хүний нэр | Хүний нэр |
| 3                                                                                             | МОН           | Д.Алтантөгс | Хүний нэр | Хүний нэр |
| 4                                                                                             | МОН           | Д.Алтантөгс | Хүний нэр | Хүний нэр |

Согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газруудад хууль тогтоомжийн хэрэгжилт, стандартын хангуулах зорилгоор аттестатчиллын шалгалтыг 2 үе шаттайгаар зохион байгуулахаар УБЗАА-аас удирдамжийн төсөлд тусгах санал болон дүүрэг дэх ажлын хэсэгт ажиллах холбогдох албан хаагчдийн нэрсийг УБЗАА-ны Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэст хүргүүлэв.

УБЗАА-наас дүүргийн согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Зөрчлийн тухай хуулийг худалдаа 16 үйлчилгээ эрхлэгчдэд сурталчлах сургалтыг цахим, болон танхимаар зохион байгуулав. Сургалтад согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй 8 худалдаа, хоол үйлдвэрлэлийн эрхлэгч, ТХҮХ-ийн худалдаа үйлчилгээ, үйлдвэрлэл хариуцсан ахлах мэргэжилтэн нар хамрагдав.




Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн эрхийг хамгаалах орон тооны бус салбар зөвлөлийн Ажлын хэсэг худалдаа үйлчилгээний 22 байгууллагуудад хяналт, шалгалт хийж, жин хэмжүүр, лангуун дээрх болон кассын үнийн зөрүүг арилгах талаар заавар, зөвлөмжийг өгөх, зөрчлийг барагдуулж, зөрчлийг газар дээр нь арилгав.



Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газраас зохион байгуулсан зөвлөлдөх уулзалтад хамрагдав. Хүнс, хөдөө аж ахуйн газраас гаргасан Худалдаа, явуулын хоолны зөвлөмжийг худалдаа үйлчилгээний 11 ХХК болон иргэн хүргэн ажиллав.



Дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс, Цагдаагийн хэлтэс хамтран 2023 оны 05 дугаар сарын 06-ны өдөр Цагдаагийн хэлтсийн хурлын танхимд Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Зөрчлийн тухай хуулийг худалдаа үйлчилгээ эрхлэгчдэд сурталчлах сургалтыг зохион байгуулав. Сургалтад согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй 8 худалдаа, хоол үйлдвэрлэлийн эрхлэгч, тамхи худалдан борлуулдаг 6 захирал, ТХҮХ-ийн худалдаа үйлчилгээ, үйлдвэрлэл хариуцсан ахлах мэргэжилтэн нар хамрагдав.



ТАЙЛАН БИЧСЭН  
ТОХИЖИЛТ, ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Ё.ГЭРЭЛЦЭЦЭГ

Ё.ГЭРЭЛЦЭЦЭГ